



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/455

Арвайхээр

**Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй
болгох тухай**


Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 4.7 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 07/05 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.1, 3.6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тавигдах шаардлагыг хангасан 6 сумын 25 цэгийн сунгалтыг нэгдүгээр, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хүссэн 2 сумын 9 цэгт хоёрдугаар хавсралтаар баталж, тусгай зөвшөөрлийг тус тус 2 жилийн хугацаатай олгосугай.

2. Хууль тогтоомж, дүрэм, журамд заасан стандартын шаардлага хангаагүй Д.Энхбаатар эзэмшигчтэй “Бор хул” баарны архи, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлтийн дагуу цуцалж, хүчингүй болгосугай.

3. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий худалдаа, үйлчилгээний газруудад хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газар (О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100774

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 27 ны өдрийн 17 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



Аймгийн архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл сунгаж буй худалдаа, үйлчилгээний газрууд

Д/д	Худалдаа, үйлчилгээний газрын нэр	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Байршил
1.	Г.Хүрэлбаатар	“Хобби” баар	Арвайхээр сум, 3 дугаар баг
2.	“Тотал дистрибушин ХХК	“Тотал дистрибуши ХХК бөөний төв	Арвайхээр сум, 5 дугаар баг
3.	А.Наранхүү	“Бумбат наран” супермаркет	Арвайхээр сум, 5 дугаар баг
4.	О.Эрдэнэцэцэг	“Баянгол” супермаркет	Арвайхээр сум, 5 дугаар баг
5.	Б.Цогбаяр	“Дэлгэрэх” хүнсний дэлгүүр	Арвайхээр сум, 6 дугаар баг
6.	Б.Мөнхтогтох	“Тэргүүн” хүнсний дэлгүүр	Арвайхээр сум, 8 дугаар баг
7.	Г.Алтангэрэл	“Хангарьд” хүнсний дэлгүүр	Арвайхээр сум, 9 дугаар баг
8.	Т.Болдбаатар	“Өгөөж тулга” хүнсний дэлгүүр	Бат-Өлзий сум, 5 дугаар баг
9.	М.Отгончулуун	“Буян-Аривжих” хүнсний дэлгүүр	Бат-Өлзий сум, 5 дугаар баг
10.	Д.Пүрэвтогтох	“Сөн далай” хүнсний дэлгүүр	Бат-Өлзий сум, 5 дугаар баг
11.	Ч.Батболд	“Есөн-Эрдэнэ” хүнсний дэлгүүр	Бат-Өлзий сум, 5 дугаар баг
12.	С. Отгонбаяр	“Есөн уулзвар” хүнсний дэлгүүр	Баян-Өндөр сум, 5 дугаар баг бумбат 101 тоот
13.	Б. Долгоржав	“Баянбулаг” хүнсний дэлгүүр	Баян-Өндөр сум, 5 дугаар баг бумбат 111 тоот
14.	М. Ариунбаяр	“Асар” хүнсний дэлгүүр	Баян-Өндөр сум, 5 дугаар баг бумбат 322 тоот
15.	Д. Энхбаяр	“Оргил” хүнсний дэлгүүр	Баян-Өндөр сум, 5 дугаар баг бумбат 211 тоот
16.	М. Галбадрах	“Зүлэгт” хүнсний дэлгүүр	Баян-Өндөр сум, 5 дугаар баг
17.	Д. Батмөнх	“Ууган-Ундрэм” хүнсний дэлгүүр	Баян-Өндөр сум, 5 дугаар баг бумбат 207 тоот
18.	Ө. Баянбилэг	“Өгөөмөр” хүнсний дэлгүүр	Баян-Өндөр сум, 5 дугаар баг
19.	Н. Оюунчимэг	“Баялаг” хүнсний дэлгүүр	Баян-Өндөр сум, 5 дугаар баг бумбат 209 тоот
20.	Д. Батмөнх	“Бумбат хаан” хүнсний дэлгүүр	Баян-Өндөр сум, 5 дугаар баг
21.	Ж.Шижээ	“Цагааншовх” хүнсний дэлгүүр	Хужирт сум, 4 дүгээр баг
22.	Ц.Мөнхбат	“Мөнх үржих” хүнсний дэлгүүр	Есөнзүйл сум, 2 дугаар баг
23.	Д.Санжидхорол	“Ёншхой” хүнсний дэлгүүр	Нарийнтээл сум, 2 дугаар баг
24.	“Монголий вояж” ХХК	“Мөнхтэнгэр” ресторан	Хархорин сумын Ганган-Орхон баг
25.	“Бумбат хаан” БН	“Бумбат хаан” хүнсний дэлгүүр	Баян-Өндөр сум, 5 дугаар баг

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 07 ны өдрийн 115 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Аймгийн архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож буй худалдаа, үйлчилгээний газрууд

Д/д	Худалдаа, үйлчилгээний газрын нэр	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Байршил
1.	Б.Чинбат	“Арвижих” хүнсний дэлгүүр	Арвайхээр сум, 11 дүгээр баг
2.	Б.Цэрэнпагам	“Ургац” хүнсний дэлгүүр	Арвайхээр сум, 9 дүгээр баг
3.	А.Ариунаа	“Баялаг ундарга” минимаркет	Арвайхээр сум, 13 дугаар баг
4.	Г.Доржпагам	“Хөнөг” хүнсний дэлгүүр	Бат-Өлзий сум, 1 дүгээр баг
5.	Н.Миегомбожа в	“Орхон түшээ” хүнсний дэлгүүр	Бат-Өлзий сум, 1 дүгээр баг
6.	Б.Энхмаа	“Энх-Мөнх” хүнсний дэлгүүр	Бат-Өлзий сум, 5 дугаар баг
7.	М.Авиржаргал	“Очир” хүнсний дэлгүүр	Бат-Өлзий сум, 5 дугаар баг
8.	Ж.Мөнхбат	“Алтан нутаг” хүнсний дэлгүүр	Бат-Өлзий сум, 3 дугаар баг
9.	Н.Дэлгэрмаа	“Мөнхдэлгэрэх” хүнсний дэлгүүр	Бат-Өлзий сум, 3 дугаар баг

-оОо-